



ISSUE #17

13 January 2012

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Шинэ Жилийн Мэнд Хүргэе! Энэ жил өмнөө тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд тань та бүхэнд амжилт хүсье.

Та бүхнийг өвлийн амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт итгэлтэй байна. Yvonne бид хоёр Улаанбаатарт үлдэж ууланд авирсандаа баяртай байна. Одоо хичээл эхлээд хоёр нохой маань амарч эхэлж байна.



Бангкок хотноо болсон багш нарыг сонгон шалгаруулах арга хэмжээнд оролцохоор Mrs. Hanselmann, Mr. Elya нар амралтын хоногуудаа дутуу үлдээн ажилдаа орлоо. Одоо тэд Хонг Конг хотноо хоёр дахь арга хэмжээнд оролцож байгаа. 1 сарын 25-нд Дэд Захирал Туул бид хоёр Торонто, Бостон хотноо болох багш нарыг сонгон шалгаруулах уулзалтуудад оролцохоор явах гэж байна. Эдгээр арга хэмжээнд оролцож бид ОУДС-ийн сурагчиддаа хичээл заах хамгийн сайн багш нарыг сонгон шалгаруулж ажилд авдаг.

Бид багш нарыг хэрхэн сонгон шалгаруулж авдаг вэ? Юуны түрүүнд бид олон улсын сургуулиудад ажилд орох хүсэлтээ илэрхийлсэн багш нар болон сургуулиудыг холбож өгдөг багш нарыг сонгон шалгаруулах туршлагатай мэргэжлийн байгууллагуудад ханддаг. Эдгээр байгууллагууд нь багш нарыг сонгон шалгаруулах арга хэмжээнүүдийг зохион байгуулж бидэнд багш нарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргэдэг.

Бид эхний ээлжинд ажилд орох өргөдөл гаргасан багш нарыг тухайн хичээлийг заах багшлах эрхтэй эсэхийг нягталж үздэг. Үүний дараагаар тэдний ажилласан жилийн туршлага, ялангуяа IB хөтөлбөрийг зааж байсан эсэхийг харгалзан үздэг. Хэрвээ энэ талын туршлага байхгүй бол IB хөтөлбөртэй ижил төстэй сурагч төвтэй сургалт явуулж байсан туршлагатай эсэхийг шалгадаг.

Боловсролын талаар тэдний баримталдаг үзэл бодлыг бид сайтар тунгаан үзэж тухайн багш нарын талаар мэргэжлийн байгууллагын гаргасан тодорхойлолтыг нягтлан үздэг. Энэ бүхнийг шалгасаны эцэст бид тухайн багшийг ажилд авах талаар сонирхож байвал урьдчилсан ярилцлага хийдэг. Урьдчилсан ярилцлагын дараа эдгээр багш нар манай ОУДС-д тохирох мэргэжлийн сайн багш нар байвал хоёрдахь дэлгэрэнгүй ярилцлагыг хийдэг. Үүний дараагаар эдгээр багш нар манай сургуульд тохирох сайн багш нар мөн гэдгийг тодорхойлсоны үндсэн дээр бид тэдэнд ажилд авах саналаа хэлдэг.

Энэ шатанд бид тухайн багшийг ОУДС болон Улаанбаатар хот, Монгол орны нөхцөл байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг уриалж манай багш нартай холбогдож сургуулийн болон УБ-ын талаар мэдээлэл авч сонирхсон асуултандаа хариулт авахыг дэмждэг. Энэ бүх үйл явцын дараа бид тухайн багшийг ажилд авах асуудлыг шийддэг.

FRONT PAGE— THE MEDEE IS AVAILABLE ONLINE EACH WEEK AT: WWW.ISUMONGOLIA.EDU.MN

THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar



Бид ОУДС-д ямар багшийг ажилд авдаг вэ? Юуны түрүүнд хамгийн чухал нь сурагчдыг сургах үйл явцыг болон сурагчдын эрх ашгийг эн тэргүүнд тавидаг, сурагчидтайгаа сайтар харилцаж тэдэнд санаа тавидаг багш нарыг бид ажилд авахыг хүсдэг. Сурагчдад зөвхөн дүн тавихын төлөө биш харин тэднийг сургахын төлөө үнэлдэг, сурагчдыг сургахын тулд шаргуу хөдөлмөрлөдөг, бусад багш нартайгаа хамтран хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөгөө боловсруулдаг, мэргэжлээ дээшлүүлдэг, өөрсдөө бусдаас байнга суралцдаг багш нарыг бид ажилд авах хүсэлтэй байдаг.

Адал явдалд дуртай, идэвхтэй, байгаль орчинтой харьцаж аялах дуртай, тодорхойгүй байдлыг давж гарах чадвартай, амьдралын зөв хэв маягийг хэвшүүлсэн, амархан сэтгэлээр унадаггүй, сэтгэлээр унасан ч үүнийгээ давж гарах чадвартай тийм багш нарыг бид эрэлхийлдэг. Бид Улаанбаатарын амьдралд болон ОУДС-д амархан дасаж зохицох чадвартай бидний тодорхойлсон стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд идэвхтэй хувь нэмэр оруулах багш нарыг ажилд авахыг хүсдэг.

Чадварлаг, сайн багш нарыг сонгон шалгаруулж сургуульдаа ажиллуулах нь удирдлагууд бидэнд оногддог хамгийн чухал хариуцлага байдаг. ОУДС-ийн удирдлагууд бид энэ хариуцлагаа сайтар ухамсарлаж энэ ажлыг зөв хийхийн тулд өөрсдийн бүх хүч чадлыг дайчлан ажиллана гэдэгт та бүхэн итгэлтэй байж болно.



Захирал, Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

1 сарын 16-23	Дипломын Урьдчилсан шалгалт (12-р анги)
1 сарын 18	ЭББ-ийн хурал 8:20
1 сарын 23-25	Дипломын 11-р ангийн 1-р семестрийн шалгалт
1 сарын 27	1-р семестр дуусна
1 сарын 30	2-р семестр эхэлнэ
1 сарын 31	3-р улирлын дугуйлангууд хичээллэж эхэлнэ

АНХААРУУЛГА

ОУДС-ийн Машины Зогсоол дээр сурагчдыг буулгахад баримтлах анхааруулга



Өглөө бүр ОУДС-ийн машины зогсоол дээр маш олон тээврийн хэрэгсэл орж ирж зогсож буцаж гарч байна. Ихэнх жолооч нар олон жижиг хүүхдүүд машинаасаа бууж зам хөндлөн гарч байгаа гэдгийг сайтар мэдэж байна. Гэхдээ зарим жолооч нар аль болох хүүхдээ хурдан буулгаад машины зогсоолоос хар хурдаараа буцаж гарах ганцхан бодолтой мэт л үйлдэл хийж байна. Тэд бусад тээврийн хэрэгслүүд болон машинаас бууж байгаа бусад хүүхдүүдийн талаар бодохгүй, машинаа зогсоолд зөв байрлуулалгүй зогсоолд орж ирж байгаа бусад машинуудын хөдөлгөөнд саад учруулж байна. Зарим нь бүр чөлөөтэй хурдны зам дээр явж байгаа мэт машины зогсоолын дунд бусад машинуудыг гүйцэд түрүүлэх байдал гаргаж байна.

Бид жолооч нарт тодорхой шаардлага тавидаг. Жолооч нар урд замаар хурдаа сааруулж орж ирээд явган хүний зам болон арын хашааг дагуулан зогсоолд машинаа зөв байрлуулна. Ухрахдаа болгоомжтой ухарч хөдөлж буй бусад машинуудын араас явна. Машины зогсоол дээр ямар ч машин бусад машиныг гүйцэж түрүүлэх ёсгүй. Бүх жолооч нар анхаарал болгоомжтойгоор хойд гарц руу явах ёстой. ОУДС-ийн эргэн тойронд та бүхэн цагт 25 км хурдтай явах ёстой.

Бид ОУДС– ийн машины зогсоол дээр машинаа зөв байрлуулахгүй байдлыг болон болгоомжгүй хурд хэтрүүлэн явахыг хүлээн зөвшөөрөхгүй. Эцэг эхчүүд та бүхэн хүүхдүүдээ жолооч нараар нь хичээлд нь хүргүүлдэг бол сургуулийн орчимд анхаарал болгоомжтой машинаа жолоодож, машины зогсоол дээр машинаа зөв байрлуулж байхыг жолооч нартаа анхааруулж өгнө үү. Сургуулийн орчинд машинаа анхаарал болгоомжтой жолоодох талаар бидний тависан шаардлагыг эсэргүүцсэн буюу зөрчсөн тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бид бүртгэж замын цагдаад мэдэгдэх болно.

Манай сурагчдын амь нас, аюулгүй байдал бидний хувьд хамгийн чухал асуудал тул анхаарал болгоомжгүй жолоо бариснаас болж бид сурагчдынхаа аюулгүй байдлыг эрсдэлд оруулахыг хүсэхгүй байна.

Захирал Robert Stearns